



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.14 № 01/17 ДУА-2017/101/СТА - ТШЗ

Г САЙХАН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.АМАРЖАРГАЛ ТАНАА

Г Зөрчил арилгүүлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны санхүүгийн тайландаудит хийх явцад насжилт өндөртэй 559,658.00 /Таван зуун тавин есөн мянга зуугаан зуун тавин найм/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.6-д /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг ходлогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгүүлах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.2-т /Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнээс ондөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн/, 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглогийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

000000035

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Амаржаргал, нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹: ШИНЖЭЭЧ  Ж.УГТАХБАЯР	ЗӨВШӨӨРСӨН: ЗАХИРАЛ НЯГТЛАН БОДОГЧ  САМАРЖАРГАЛ Г.БУМ-АЮУШ
--	---

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, толборийн актыг цаг хугацаанд нь биелүүлэсгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ!